



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 6-р сарын 4-өөс
6-р сарын 11-ний байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 6-р сарын 4-өөс 6-р сарын 11-ний байдлаар

КОВИД-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах чиглэлд улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 13 дахь дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Дэлхийн банк** 6-р сарын 8-нд нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа дэлхийн эдийн засаг **2020 онд 5.2 хувиар агших, 2021 онд 4.2 хувиар өсөх төсөөллийг зарлалаа**. Хөгжсөн орнуудын эдийн засаг Дэлхийн II дайнаас хойших хамгийн гүнзгий уналттай нүүр тулах хүлээлттэй байгаа бол, хөгжиж буй орнуудын эдийн засаг сүүлийн 60 жилийн хугацаанд анх удаагаа агшихаар байгааг онцлов. Мөн хөгжиж буй орнуудын 70-100 орчим сая хүн нэн ядууралд өртөж, дэлхийн нэг хүнд ногдох орлогын хэмжээ 3.6 хувиар буурна гэж тооцоолжээ. Дэлхийн улс орнуудын 90% орчимд нэг хүнд ногдох ДНБ буурах төсөөлөлтэй байгаа бөгөөд энэ нь 1870 оноос хойш хамгийн өргөн хүрээг хамарсан эдийн засгийн уналтыг бий болгохоор байна. Хэрэв сөрөг нөхцөл байдал үргэлжилбэл эдийн засгийн төлөв суурь төсөөллөөс муудаж, дэлхийн эдийн засаг 2020 онд 8 хүртэлх хувиар, хөгжиж буй орнуудын эдийн засаг 5 хүртэлх хувиар агшиж болзошгүйг анхаарууллаа.

Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд

	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	2020 он				
			Дэлхийн эдийн засгийн өсөлт	Хятадын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт	ОХУ-ын өсөлт
1	Дэлхийн банк	6/08/2020	-5.2%	1.0%	-6.1%	-9.1%	-6.0%
2	OECD	6/10/2020	-6.0%	-2.6%	-7.3%	-9.1%	-8.0%
3	RaboResearch	6/09/2020	-4.1%	1.2%	-5.7%	-9.1%	

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудаснууд

- **Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас** 6-р сарын 10-ны тайландаа КОВИД-19-ийн хоёр дахь давлагаа гарахгүй тохиолдолд дэлхийн эдийн засаг 2020 оны эхний хагаст 12 хувиар, **2020 онд нийт 6 хувиар агшихаар, 2021 онд 5.2 хувийн**

өсөлттэй байхаар төсөөлжээ. Ажилгүйдлийн түвшин 2019 онд 5.4 хувь байсан бол 2020 онд 9.2 хувь хүрч өсөхөөр байна. КОВИД-19-цар тахлын дэлхийн эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөө сүүлийн 100 жилд тохиолдож байгаагүйгээр гүнзгий байх хүлээлттэй

байгаа бөгөөд эргээд хэвийн болоход олон жил шаардагдахаар байгааг онцлов. Хэрэв оны сүүлийн улиралд цар тахлын хоёр дахь давалгаа гарвал эдийн засгийн үр дагавар үүнээс ч гүнзгий буюу дэлхийн эдийн засаг энэ онд 7.6 хувиар агшиж, ирэх онд 2.8 хувиар буюу алгуур сэргэнэ гэж тооцоолжээ. Цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, эмзэг бүлэгт хүрч туслах, тогтвортой өсөлтийг дэмжих оновчтой хөрөнгө оруулалтыг хийхэд улс орнуудын төсвийн дэмжлэг чухал ач холбогдолтой болохыг онцолжээ.

- **АНУ-ын Холбооны Нөөцийн Банк (ХНБ) 6 дугаар сарын хурлаар бодлогын хүүгээ 0-0.25%-д хэвээр хадгалж, 2022 оны төгсгөл хүртэл 0 орчим хувьд хадгалахаар зорьж буйгаа мэдэгдлээ.** ХНБ-аас АНУ-ын эдийн засаг 2020 онд 6.5 хувиар агшиж, 2021 онд ДНБ-ийн бодит өсөлт 5%, 2022 онд 3.5% хүрнэ гэж төсөөлжээ. Ажилгүйдлийн түвшин 2020 онд 9.3%, 2021 онд 6.5%, 2022 онд 5.5% байхаар байна. Түүнчлэн сард 80 тэрбум ам.долларын Засгийн газрын үнэт цаас, 40 тэрбум ам.долларын моргейж барьцаалсан үнэт цаас худалдаж авахаа мэдэгдэв. ХНБ-ийн тэргүүн Ж.Повелл эдийн засаг энэ оны 2 дугаар хагасаас сэргэж, мөнгөний бодлого эдийн засгийг дэмжсэнээр сэргэлт дараагийн жилүүдэд үргэлжилнэ гэж хэлэв. Гэхдээ Ковид-19-ийн үеийн эдийн засгийн төсөөлөлд тодорхой бус байдал их бөгөөд, эдийн засаг хэрхэн сэргэх нь вирусийг хяналтад оруулахаас ихээхэн хамаарахыг онцлов.
- **Европын төв банк цар тахалтай тэмцэх бодлогын хүрээнд худалдан авах бондын хэмжээгээ 600 тэрбум еврогоор нэмэгдүүлж, нийт 1.35 их наяд еврог 2021 оны 6-р сарыг дуустал худалдан**

авахаар болсноо 6-р сарын 4-нд зарлав. Европын төв банкны шинэчилсэн төсөөллөөр **Евро бүсийн эдийн засаг 2020 онд 8.7 хувиар агших¹**, ирэх онд 5.2 хувиар өсөхөөр байна. Мөн бүсийн инфляц энэ онд 0.3 хувь, ирэх онд 0.8 хувьтай буюу зорилтот 2 хувийн түвшнээс доогуур гарахаар байна. Евро бүсийн барилгын салбарын PMI индекс 4-р сард түүхэн доод түвшин болох 15.1-д хүрсэн бол 5-р сард 39.5 гарч, салбарын агшилт үргэлжиллээ².

- **Оросын төв банк** ирэх долоо хоногт **бодлогын хүүгээ** Зөвлөлт Холбоот Улс задарснаас хойших түүхэн доод хэмжээнд хүргэж **бууруулах хүлээлттэй байна.** Бодлогын хүү одоогоор 5.5 хувь байгаа бөгөөд Оросын төв банкны Ерөнхийлөгч Э.Набиуллина бодлогын хүүг 6-р сарын 19-ний өдрийн хурлаараа 1 нэгж хувиар бууруулах дохиог өгчээ. Оросын Төв банк энэ онд ОХУ-ын эдийн засаг 4-6 хувиар агшина гэж төсөөлж байгаа бол OECD байгууллага ОХУ-ын эдийн засаг 8-10 хувиар агшихаар төсөөлж байна. Мөн ОХУ-ын төсвийн алдагдал энэ онд OECD-ийн тооцоогоор ДНБ-ий 2.5-2.6 хувьтай тэнцэхээр байгаа бол ОХУ-ын засгийн газрын мэдээлснээр ДНБ-ий 8.5 хувьтай тэнцэж болзошгүй гэж үзэж байна. HIS Markit судалгааны байгууллагын тооцоогоор ОХУ-ын аж үйлдвэрийн PMI индекс 4-р сард 31.3 байсан бол 5-р сард 36.3 болж буурах хурд саарчээ.
- **“S&P” агентлаг 6-р сарын 9-нд Япон улсын Засгийн газрын зээлжих зэрэглэлийн цаашдын төлөвийг эерэг байсныг тогтвортой болгож буулгалаа.** Цар тахлын үр нөлөөг даван туулахад зарцуулах зардлаа нэмэгдүүлж байгаагийн улмаас тус улсын санхүүгийн орчин тогтворгүй байгаа бөгөөд 2-3 жилд

¹ Европын төв банк 3-р сард Евро бүсийн өсөлт 0.8 хувиар агшихаар төсөөлж байсан юм.

² Уг индекс 50-с дээш утгатай бол сэргэлт, 50-с доош утгатай бол агшилт/уналтыг илтгэдэг.

хэвийн байдалдаа орох төлөвтэй гэж үзжээ. Тус улс эдийн засгаа хамгаалах хоёр дахь багц хөтөлбөр баталснаар нийт

дэмжлэгийн хэмжээ ДНБ-ий 40% орчимд хүрээд байна.

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын экспорт 5-р сард өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буюу хүлээлтээс багаар буурсан бол импорт 16.7 хувиар агшжээ.** Энэ нь эдийн засгийн идэвхжил алгуур сэргэж байгаа хэдий ч, хэвийн түвшинд хүрэх болоогүйг илтгэж байна. Худалдааны тэнцэл 4-р сард 45.3 тэрбум ам.долларын ашигтай байсан бол 5-р сард ашиг 62.9 тэрбум ам.доллар хүрч нэмэгдэв. Хятадын экспортын өсөлтөд эмнэлгийн бүтээгдэхүүн хэрэгслүүдийн экспорт 88.5 хувиар, нэхмэл утас, даавууны /үүнд маск багтана/ экспорт 77.3 хувиар нэмэгдсэн нь эерэгээр нөлөөлөв. Харин хувцас, гоёл чимэглэлийн экспорт 27 хувиар, тоглоомын экспорт 10 хувиар тус тус буурчээ. Хэдийгээр 5-р сард түүхий нефтийн импортын биет хэмжээ 19.2 хувиар, төмрийн хүдрийн импортын биет хэмжээ 3.9 хувиар тус тус өссөн ч нефтийн үнэ 5-р сард 30 хувиар унаж, байгалийн хийн импорт буурсан нь тайлант хугацаанд Хятадын импорт агшихад голлон нөлөөлөв.
- **Хятадын инфляц 5-р сард хүнсний үнэ алгуур саарч ³ байгаатай холбоотойгоор үргэлжлэн буурлаа.** 2020 оны 4-р сард 3.3 хувиар нэмэгдсэн ХҮИ 5-р сард хүлээлтээс доогуур 2.4 хувиар нэмэгдэв. Хүнсний инфляцыг өсгөх нөлөө үзүүлсээр байгаа гахайн махны үнийн өсөлт 3-р сараас хойш алгуур саарч байна. Тухайлбал, гахайн махны үнэ 4-р сард өмнөх оны мөн үеэс 117 хувиар өссөн бол 5-р сард өсөлтийн

эрч бага зэрэг суларч 93 хувиар өсчээ. Газрын тосны үнэ буурснаар дотоодын шатахууны үнэ буурч, инфляцыг бууруулах нөлөө үзүүллээ. Суурь инфляц⁴ сүүлийн 4 сарын хугацаанд 1.5 хувиас бага түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд 5-р сард 1.1 хувь байв.

- **Хятадын үйлдвэрлэгчдийн үнийн индекс (ҮҮИ) 4-р сард 3.1 хувиар буурсан бол 5-р сард хүлээлтээс доогуур 3.7 хувиар буурлаа.** Гадаад эрэлт төдийлөн нэмэгдээгүй, түүхий эдийн эрэлт бага байгаа нөлөөгөөр тус индексийн хүнснээс бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэ үргэлжлэн буурчээ. Төмрийн хүдрийн үнэ 4-р сард өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар, 5-р сард 8 хувиар буурав. Газрын тос, байгалийн хийн үнэ өмнөх оны мөн үеэс 57.6 хувиар буурсан боловч газрын тосны үнэ эргээд нэмэгдэж эхэлснээр ҮҮИ-ийг бууруулах дарамт багасах төлөвтэй байна. Хятадын автомашины үйлдвэрлэлийн үнэ 20 дахь сардаа үргэлжлэн буурч, 5-р сард өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурав.
- Хятад Улс гахайн махны хэрэглээг орлуулах бүтээгдэхүүнийг бэлтгэх арга хэмжээг авч байна. 2020 оны 4-р сард Азийн улс орнууд руу экспортолсон Бразилын үхрийн махны экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2 дахин өсч 84,000 тонн хүрээд байна.
- **Хятадын төсвийн бодлого:** Хятадын Ардын Их Хурлаар 2020 оны төсвийн

³ Хүнсний үнэ 4-р сард өмнөх оны мөн үеэс 14.8 хувиар өссөн бол 5-р сард 10.6 хувиар өсч, өсөлтийн хурд саарав.

⁴ Суурь инфляцд хүнсний үнэ болон эрчим хүчний хэрэглээний үнэ ороогүй.

алдагдлыг өсгөж, 3.6 хувьд хүргэхээр баталсан. Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд 2020 онд Хятадын Засгийн газар нийт 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийх төлөвтэй байна. Цаашид зээлийн өсөлтөөр дамжуулж эдийн засгийг тэтгэх арга хэмжээнүүд үргэлжлэх хүлээлттэй байна. Шинээр олгосон юаний зээлийн хэмжээ 4-р сард 1.7 их наяд юань байсан бол 5-р сард 1.48 их наяд юань хүрч хүлээлтээс багаар өсөв. Харин Засгийн газрын бонд олголтын квот 2019 онд 2.15 их наяд юань байсан бол 2020 онд 3.75 их наяд юань хүрч нэмэгдэхээр батлагдсан. Гэхдээ корпорэйт бонд өмнөх сарын түвшнээс мэдэгдэхүйц буураад байна.

- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Их хурлаар эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан мөнгөний уян хатан бодлого баримтална гэдгийг мэдэгдэв. Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд КОВИД-19-өөс үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулахын тулд бодлогын хүүгээ 0.5-0.6 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна⁵.

Түүнчлэн, ХАБ 6-р сарын 1-ний мэдэгдэлдээ 400 тэрбум юанийн квоттой арилжааны банкуудын жижиг ААН-үүдэд олгосон зээлийг худалдаж авах зээлийн шинэ бодлогын хэрэгсэл хэрэглэхээр болсноо мэдэгдлээ. Энэхүү шинэ хэрэгслээр дамжуулж ХАБ арилжааны банкуудын олгосон зээлийн 40 хувийг авах боловч, зээлийн эрсдэлийг хүлээхгүй бөгөөд хүүний орлогыг авахгүй юм. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

⁵ ХАБ өмнө нь бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан.

3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл:

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 81.1%-тай биелж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.4%-иар буурсан байна. 2020 оны 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн нийт орлого 3,343.4 тэрбум төгрөг гарсан нь төлөвлөснөөс 18.9%-иар буюу 777.2 тэрбум төгрөгөөр дутсан үзүүлэлт байна.

Татварын орлогын дэлгэрэнгүй задаргааг авч үзэхэд 2020 оны 5 дугаар сард нийт 602.4 тэрбум төгрөгийн татварын орлого бүрдсэнээс:

- 7% (44.4 тэрбум төгрөг) нь ААНОАТ,
- 11% (65.3 тэрбум төгрөг) нь ХХОАТ,
- 20% (120.1 тэрбум төгрөг) нь НДШ,
- 32% (191.2 тэрбум төгрөг) нь НӨАТ,
- 33% (198.6 тэрбум төгрөг) нь бусад татварын орлого байна.

Энэ нь 2019 оны 5 дугаар сарын татварын орлоготой ижил бүтэцтэй байна.


Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 77.9%-тай гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32%-иар өссөн үзүүлэлт бөгөөд урсгал зардал болон хөрөнгийн зардал харгалзан 27.3% (873.2 тэрбум төгрөг), 57.6% (301.8 тэрбум төгрөг)-иар өсжээ.

Хүснэгт 2. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Татварын орлого	3,692,717	3,055,561	82.7%	-637,156.5
Татварын бус орлого	427,889	287,857	67.3%	-140,031.5
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	4,120,606	3,343,418	81.1%	-777,188.0

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Зураг 1. Татварын орлогын задаргаа, сараар



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Хүснэгт 3. Нийт зарлага ба цэвэр зээл


	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Урсгал зардал	4,784,409	4,076,948	85.2%	-707,461.2
Хөрөнгийн зардал	1,472,980	825,795	56.1%	-647,185.4
Цэвэр зээл	58,734	19,509	33.2%	-39,224.7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	6,316,124	4,922,252	77.9%	-1,393,871.4

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Гадаад худалдаа:


2020 он гарснаас хойш анх удаа гадаад худалдааны тэнцэл 13.9 сая ам.долларын ашигтай буюу эерэг гарлаа. Гэхдээ энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлт хэвээр байна. Тухайлбал, 2020 оны 5 дугаар сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1579.7 сая ам.доллар (28.3%)-аар буурсан буюу экспорт 1257.2 сая ам.доллар (38.5%)-аар, импорт 322.6 сая ам.доллар (13.9%)-аар тус тус буурсан байна.

Зураг 2. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 3. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зөвхөн 5 дугаар сард 632.7 сая ам.долларын экспорт, 406.1 сая ам.долларын импорт хийсэн байна. Энэ нь өмнөх сарын мөн үеийнхтэй харьцуулахад экспорт 87.3% өсөж, импорт 4.4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Зарим нэр төрлийн барааны экспорт, импортын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс дараах байдлаар буурсан байна.

Барааны нэр	Экспорт		Импорт	
	сая \$	%	сая \$	%
Эрдэс бүтээгдэхүүн	-1,135.14	-41.2%	-104.70	-20.7%
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	-21.14	-74.9%	-1.74	-1.0%
Арьс ширэн бүтээгдэхүүн	-2.57	-31.4%	-0.75	-25.9%
Нэхмэлийн материал, эдлэл	-146.80	-71.6%	0.70	2.1%
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	-1.16	-30.4%	-139.50	-31.3%
Мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	-18.82	-74.2%	-3.79	-11.4%

Зураг 4. Инфляц, сараар



Эх сурвалж: Монголбанк

Жилийн инфляц 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 3.3%, Улаанбаатар хотын хэмжээнд 3.5% буюу өмнөх сараас буурсан. Энэ нь Ковид-19 цар тахлаас сэргийлэх хориг арга хэмжээтэй холбоотойгоор газрын болон агаарын тээврийн үйлчилгээ багасч, шатахууны үнэ буурсантай холбоотой байна.

Зураг 5. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Дэлхийн санхүүгийн зах зээлд ковид-19-ээс үүдэлтэй эрсдэл, тодорхойгүй байдал нэмэгдсэнээр голлох хөрөнгийн биржийн индексүүдийн үнэ унаад байсан бол сүүлийн 1 сарын хугацаанд бага зэрэг өслөө.

Эдийн засгийн зогсонг байдлаас үүдэн Монголын хөрөнгийн захад бууралт үргэлжилж байна.

2020 оны 6 дугаар сарын 11-ний өдөр I, II, III ангиллын 25 хувьцаат компанийн 42,366,215.25 төгрөгийн үнийн дүн бүхий 726,023 ширхэг хувьцаа арилжаалснаас 9 хувьцаат компанийн хувьцааны ханш өсч, 12 хувьцаат компанийн хувьцааны ханш буурсан бол 4 үнэт цаасны ханш тогтвортой байв. Улмаар ТОП-20 индексийн үзүүлэлт 16047.84 болж өнгөрсөн 7 хоногоос 0.2%, оны эхнээс 16.9%-иар буураад байна.

Зураг 6. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, өндөржүүлсэн бэлэн байдлын үед 2020 оны хаврын тариалалтад онцгой анхаарч, тариалангийн талбайг нэмэгдүүлэн тариалах, ажлын байрыг хадгалж үлдэх, хүн амыг дотооддоо тарьж ургуулсан хүнсний бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 2020 онд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд 6 нэр төрлийн 86.6 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр болсноос гадна хаврын тариалалтыг 15-20 хувиар нэмэгдүүлэхээр боллоо.

Засгийн газрын 5-р сарын 20-ны өдрийн ээлжит хуралдаанаар цар тахлын үед эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний болон тусгай албан хаагчдыг түрээслээд, өмчлөх хэлбэрээр орон сууцтай болгох тогтоолын төслийг хэлэлцэж баталлаа.

Энэхүү тусгай хөтөлбөрт төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч буюу эмч, сувилагч, асрагч, жолооч, үйлчлэгч, онцгой байдлын аврагчид, хил, гаалийн байцаагч нар, цэвэршүүлэх байгууламжийн засварчин, техникчид, тагнуул, цагдаа, мэргэжлийн хяналтын байцаагч нар хамрагдах юм. Улмаар хөтөлбөрт хамрагдах албан хаагчдыг тухайн байгууллага нь хамт олныхоо саналаар ил тод шударгаар сонгох зарчим баримталж ажиллахыг Улсын онцгой комисс (УОК)-оос үүрэг болгов.

Тус тогтоолоор Засгийн Газрын 2019 оны 138 дугаар тогтоолын хавсралтаар

баталсан “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам” –ыг өөрчлөн 2.2.2-т нэмэлт өөрчлөлт орууллаа. Үүгээр түрээслэгчдэд дараах хэд хэдэн нэмэлт боломж олгогдож байна. Үүнд:


- Өмнө нь иргэн орон сууцаа тав хүртэлх жилийн дотор түрээслээд энэ хугацаандаа үлдсэн төлбөрөө гүйцээн төлж өмчлөлдөө авдаг байсан бол хугацааг 15 хүртэлх жил болгон сунгав. Өөрөөр хэлбэл, иргэн улсын төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөр барьсан орон сууцнаас сонговол тав хүртэлх жил, бусад хувилбарын санхүүжилтээр барьсан барилгаас сонговол 15 хүртэлх жил түрээслээд түрээслэх явцдаа сар бүр хуваарийн дагуу хэсэгчлэн төлсөөр түрээсийн орон сууцаа худалдан авч, өмчлөх боломжтой байхаар тусгаж өгчээ;
- Зөвхөн улс, орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөр барьсан орон сууцнуудаас сонголт хийх болзол тавьдаг байсан бол одоо гадаад, дотоодын зээл буцалтгүй тусламжаар болон хувийн аж ахуй нэгжүүд өөрийн хөрөнгөөр барьсан 100 хувь ашиглалтад орсон байрнуудаас сонгох боломжийг бүрдүүлэв;
- Зай талбайн хязгаарыг цуцлав;
- Албан хаагч өөрийн орлогодоо тулгуурлан, хүссэн байраа сонгох боломжтой болов;
- 30 хүртэл хувийн урьдчилгаа төлбөр шаарддаг байсныг цуцалж, урьдчилгаагүйгээр шууд орон сууцандаа орох боломжтой болов.

Тогтоолыг 6 сарын 15-ны өдрөөс мөрдөж эхэлнэ.

5 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Газрын тосны үйлдвэрлэлийн гарцаа танах ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн хэлцэл болон зарим улсад хориг арга хэмжээг аажмаар сулруулж, газрын тосны эрэлт буцаж сэргээсэнтэй зэрэгцэн сүүлийн нэг сард газрын тосны үнэ өсөж 42 ам.долларт хүрсэн. Гэвч 6 дугаар сарын 11-ний өдрийн арилжаагаар газрын тосны үнэ 8 хувиар огцом суларч 38.3 ам.долларт хүрсэн нь тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж байна. Хятад улсад шинэ коронавирусийн тархалтыг намжиж, эдийн засаг нь идэвхжиж, үйлдвэрүүд үйл ажиллагаагаа сэргээсэнтэй холбоотойгоор зэсийн ханш сүүлийн 2 сарын хугацаанд 20 хувиар өсөж 5900 орчим ам.долларт хүрлээ. Харин Бразил, Энэтхэг улсад халдвар эрчимтэй тархсантай зэрэгцэн төмрийн хүдрийн нийлүүлэлтэд тасалдсанаар төмрийн хүдрийн үнэ огцом өсөж 103 ам.долларт хүрчээ. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал, эрсдэл өндөр байгаа тул алтны ханш 1700-1750 ам.долларын түвшинд хэвээр хадгалагдаж байна.


Зураг 7. Зэсийн үнэ



Эх сурвалж: www.investing.com

Зэсийн үнэ. Дэлхийн зэсийн эрэлтийн тал хувийг дангаар бүрдүүлдэг БНХАУ-ын үйлдвэрүүд үйл ажиллагаагаа сэргээж, тус улсын зэсийн импорт огцом өссөнтэй холбоотойгоор сүүлийн хоёр сарын хугацаанд зэсийн үнэ аажмаар буцаж сэргэн 5,900 ам.долларын түвшинг давлаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийг давсан үзүүлэлт юм. Зэсийн гол нийлүүлэгч Перу, Чили зэрэг улсуудад коронавирусийн тархалт эрчимтэй нэмэгдэж буй нь зэсийн үнэ эргэж өсөхөд нөлөө үзүүлж байна.

Зураг 8. Газрын тосны үнэ




Эх сурвалж: www.investing.com

Газрын тосны үнэ. 5 дугаар сарын 1-ээс эхлэн ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн газрын тосны гарц танах хэлэлцээр хэрэгжиж эхлэв. Мөн зарим улсууд хориг арга хэмжээгээ аажмаар сулруулж газрын тосны эрэлт буцаж сэргэж эхэлсэнтэй зэрэгцэн газрын тосны үнэ сүүлийн нэг сар гаруй хугацаанд өсөж 42 ам.долларт хүрлээ. Гэвч 6-р сарын 11-ний өдрийн арилжаагаар Brent газрын тосны үнэ 8 хувиар суларч 38.3 ам.долларт хүрсэн нь 4-р сарын 27-оос хойших хамгийн тааруу үзүүлэлт болов.

Түүнчлэн, өнгөрсөн долоо хоногт АНУ-ын агуулахуудад хадгалагдаж буй газрын тосны хэмжээ түүхэн дээд хэмжээ буюу 538.1 сая баррельд хүрчээ.


Зураг 9. Алтны ханш



Эх сурвалж: www.investing.com

Алтны ханш. 4 дүгээр сараас эхлэн дэлхийн улс орнуудад ээлжлэн вирусийн дэлхийн бусад улс орнуудад тархалт эрчимтэй нэмэгдсэн, АНУ болон Хятад улсуудын харилцаа таагүй байгаа зэргээс үүдэн глобал зах зээлд тодорхой бус байдлыг ихэсгэж алтны ханш өсч 1700-1750 ам.долларт хэлбэлзэж байна. Энэ нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 31 хувиар буюу 400 гаруй ам.доллараар өндөр үзүүлэлт юм.

Зураг 10. Төмрийн хүдрийн үнэ



Эх сурвалж: www.investing.com

Төмрийн хүдрийн үнэ. 4 дүгээр сард төмрийн хүдрийн үнэ харьцангуй тогтвортой 80-84 ам.долларын хооронд хэлбэлзэж байсан бол гол нийлүүлэгч улсуудад шинэ коронавирусийн халдвар хурдтай тархаж буйтай холбоотойгоор нийлүүлэлт тасалдаж байна. Тодруулбал, Бразил, Энэтхэг улсад вирусийн голомт төвлөрөн, эрчимтэй тархахтай зэрэгцэн төмрийн хүдрийн ханш сүүлийн нэг сар гаруй хугацаанд 25 хувиар чангарч 103 ам.долларт хүрлээ. Нөгөө талд, Хятад улсад гангийн үйлдвэрлэл сэргэж,

төмрийн хүдрийн эрэлт их байгаа нь үнэ өсөхөд нөлөөлж байна.